



ИНД - 19

Иргэний Нисэхийн Дүрэм

Шилжилтийн дүрэм

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-19 нь дараах шаардлагыг багтаасан:

- бусад ИНД-ээр зохицуулагдаагүй үйл ажиллагааны түр зохицуулалт;
- IFR-ийн үйл ажиллагаанд GPS-төхөөрөмжийг ашиглах.
- зарим нисэхийн баримт бичгийн талаарх ИНЕГ-ын эрх;
- аэродромын цаг уурын минима болон IFR-ийн журам;
- аюулгүйн хамгаалалтын зохицуулалт;
- үнэмлэхжүүлэлтийн бусад шаардлага.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-19-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-19, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх

Анхны боловсруулалт

Хүчинтэй огноо

2019 оны ... сарын ...

Тэмдэглэл: ИНД-19-ийн анхны боловсруулалтыг монгол, англи хэл дээр, NZ Part 19 А.19-д үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг - Ерөнхий зүйл	5
19.1. Тодорхойлолт	5
19.3. Хэмжлийн нэгж	5
19.5. Иргэний нисэхийн бэлгэ тэмдэг.....	5
19.7. Согтууруулах ундаа болон эмийн бодис	6
19.9. Нэвтрэх бүсийн хяналт	6
19.11. Нисэхийн баримт бичгийг шилжүүлэх.....	6
19.13. Нөөц	6
19.15. Гадаадын агаарын хөлгийн Монгол Улс дахь үйл ажиллагаа	6
В Бүлэг - Үйл ажиллагааны ерөнхий дүрэм	7
19.103. ХАА-н нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч - статистик мэдээ	7
19.105. Нисгэгчгүй агаарын хөлөг	7
19.107. Нөөц	7
С Бүлэг – Нөөц	7
Д Бүлэг - IFR-ийн үйл ажиллагаа: GNSS	8
19.201. Хамрах хүрээ	8
19.203. Тайлбар.....	8
19.205. Нисгэгчийн мэргэшил.....	9
19.207. Анхдагч GPS үйл ажиллагаа	9
19.209. Бие даасан хэлбэрийн GPS үйл ажиллагаа	10
19.211. Нэмэлт хэлбэрийн GPS үйл ажиллагаа.....	10
19.213. GPS-ээс авсан зайн мэдээлэл	11
19.215. Минимум нислэгийн түвшин	11
19.217. Үнэлгээ хийгдээгүй замын нислэг	11
19.219. Нислэгийн төлөвлөгөө	12
Е Бүлэг - Нөөц	12
Ғ Бүлэг - Хангамжийн байгууллагын зөвшөөрөл	12
Г Бүлэг - Аюулгүйн хамгаалалт	12
19.353. Аюулгүйн хамгаалалтын хяналтад хамаарах агаарын хөлөг, хувь хүнд тавих хязгаарлалт	12
19.355. Хориглох зүйлс	13
19.357. Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх.....	13
19.359. Шүүхийн, эсхүл захиргааны хяналтад байгаа зорчигчийг тээвэрлэх	14
И Бүлэг - Ажилтан	15
19.401. Техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийг дахин шалгах	15
19.403. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын цагийн хязгаарлалт	15
19.405. Туршин нисгэгч	15
19.407. Нөөц	15
19.409. Глайдерын ажилтан	15
19.411. Ханг-глайдер болон параглайдерын нисгэгч.....	16
19.413. Хэт хөнгөн агаарын хөлөг нисгэгч	17

А Бүлэг - Ерөнхий зүйл

19.1. Тодорхойлолт

Энэ Дүрэмд, агуулгыг өөрөөр шаардсанаас бусад тохиолдолд:

Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх гэж энэ Дүрмийн дагуу олгосон, эсхүл зөвшөөрсөн нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг;

Үйл ажиллагааны бүс гэж үйл ажиллагааны бүсийн таних тэмдгээр тогтоосон, эсхүл үйл ажиллагааны байгууламж байрласан бүсийг багтаасан, агаарын хөлгийн хөдөлгөөн, эсхүл маневр хийдэг аэродром дээрх талбайг;

Шилжүүлэх мэдэгдэл гэж нийлүүлж байгаа нисэхийн бүтээгдэхүүн нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц нислэгт тэнцэх чадварын стандартад тохирч байгааг, тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт болон техник үйлчилгээний үе шатанд эргэж тогтоох замаар нотлох боломж олгож байгаа баримт бичгийг ойлгоно.

19.3. Хэмжлийн нэгж

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Монгол Улсад нисэхийн зорилгоор, Конвенцийн Хавсралт 5-д заасан Олон улсын нэгжийн системийн хэмжлийн нэгжийг хэрэглэнэ.

(b) Хавсралт 5-д заасан Олон улсын нэгжийн системийн бус нэгжийг дараах хүснэгтийн дагуу Монгол Улсад ашиглана:

зай (distance)	далайн миль (nautical mile)	NM
түвшин, өндөрлөг болон өндөр (агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой бол)	фут (foot)	ft
хурд, салхины хурдыг багтаасан	кнот (knot)	kt
босоо хурд	фут / минут (foot per minute)	ft / min

19.5. Иргэний нисэхийн бэлгэ тэмдэг

(a) Монгол Улсын иргэний нисэхийн бэлгэ тэмдгийн загварыг Дарга батална.

(b) Монгол Улсын иргэний нисэхийн бэлгэ тэмдгийг, дараахаас бусад зүйл дээр өөр байдлаар байрлуулахгүй:

- (1) ИНЕГ, түүний харъяа байгууллагын албан байр болон тээврийн хэрэгсэлд;
- (2) ИНЕГ-ын харъяа байгууллагын агаарын навигацийн байгууламж дээр;
- (3) ИНЕГ-ын харъяа байгууллагын аэродромын барилга байгууламж дээр;
- (4) ИНЕГ-ын албан захидал, аливаа баримт бичигт;

(5) Даргын бичгээр олгосон зөвшөөрөлд заасан нөхцөлийн дагуу.



19.7. Согтууруулах ундаа болон эмийн бодис

Багийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж байхдаа согтууруулах, тайвшруулах, өвчин намдаах, мансууруулах, эсхүл хүч оруулах бодис, эсхүл бэлдмэл хэрэглэсэн, эсхүл ашигласны улмаас эрүүл мэндийн хувьд, ажил үүрэг гүйцэтгэх чадвараа алдсан, эсхүл мансуурсан байдалтай байхыг хориглоно.

19.9. Нэвтрэх бүсийн хяналт

Хуулиар Даргад олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор, ИНД-140-ийн дагуу эрх олгогдсон этгээд нь Даргын шаардлагатай гэж үзсэн бүс, эсхүл талбайд нэвтрэх хяналт тавих, эсхүл хориглох арга хэмжээг авч болно.

19.11. Нисэхийн баримт бичгийг шилжүүлэх

(a) Нисэхийн баримт бичгийг бусдад шилжүүлэхгүй.

(b) Шилжүүлсэн нисэхийн баримт бичиг нь түүнийг шилжүүлэн авсан этгээдэд аливаа эрхийг олгохгүй.

19.13. Нөөц

19.15. Гадаадын агаарын хөлгийн Монгол Улс дахь үйл ажиллагаа

(a) Энэ зүйлийн (b)-гийн нөхцөлийг харгалзан, Дарга нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд шаардлагатай гэж үзэн, тухайн агаарын хөлгийн үйл ажиллагаанд тогтоосон нөхцөл, хязгаарлалт бүхий зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд, гадаадын бүртгэлтэй агаарын хөлгөөр Монгол Улсад, агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад, хөлс, эсхүл шан урамшуулалтай үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу олгосон зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрөлд заасан аливаа нөхцөл, эсхүл хязгаарлалтыг мөрдөнө.

(c) Энэ зүйл нь олон улсын хуваарьт, эсхүл олон улсын хуваарьт бус нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хамаарахгүй.

В Бүлэг - Үйл ажиллагааны ерөнхий дүрэм

19.103. ХАА-н нислэгийн үйл ажиллагаа эрхлэгч - статистик мэдээ

(a) ХАА-н агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг агуулсан тайланг Хүснэгт 1-д заасан хамрах хугацаа болон эцсийн хугацаанд Даргад хүргүүлнэ:

- (1) мэдээний хамрах хугацаа;
- (2) гэрчилгээ эзэмшигчийн нэр;
- (3) агаарын хөлгийн бүртгэлийн дугаар;
- (4) тайлангийн хугацаанд ачаалалтай хийсэн тээвэрлэлтийн тоо;
- (5) тайлангийн хугацаанд ашигласан аэродром бүрийн байрлал;
- (6) ургамлын тэжээл, хөрсний бордоо, ургамлын тархалт, эсхүл хортон шавьж устгах зорилгоор ХАА-н химийн бэлдмэл, эсхүл бусад бодис цацах нислэгийн үйл ажиллагааны үед:
 - (i) тээвэрлэсэн ачааны төрөл;
 - (ii) тээвэрлэсэн ачааны нийт жин, эсхүл хэмжээ;
 - (iii) боловсруулсан нийт талбайн хэмжээ.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу шаардсан статистик мэдээллийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц цахим, эсхүл бичгийн хэлбэрээр хүргүүлнэ.

Хүснэгт 1. Тайлангийн хугацаа

Тайлан	Хамрах хугацаа	Эцсийн хугацаа
1-р улирал	01 сарын 01-нээс 03 сарын 31	05 сарын 01
2-р улирал	04 сарын 01-нээс 06 сарын 30	08 сарын 01
3-р улирал	07 сарын 01-нээс 09 сарын 30	11 сарын 01
4-р улирал	10 сарын 01-нээс 12 сарын 31	02 сарын 01

19.105. Нисгэгчгүй агаарын хөлөг

[Хүчингүй]

19.107. Нөөц

С Бүлэг – Нөөц

D Бүлэг - IFR-ийн үйл ажиллагаа: GNSS

19.201. Хамрах хүрээ

(a) Энэ Бүлэг нь GNSS төхөөрөмжийг IFR-ийн дагуу ашиглах нөхцөл болон шаардлагыг тогтооно.

(b) Энэ Бүлэгт агуулагдсан нөхцөл болон журам нь энэ дүрэм, эсхүл холбогдох бусад ИНД-д заасан аливаа шаардлагад нэмэлт болно.

19.203. Тайлбар

Энэ Бүлэгт дараах нэр томъёоны тайлбар хамаарна:

GPS өгөгдлийн сан гэж нисэх буудал, илтгэх цэгийн навигацийн туслах хэрэгсэл, стандарт хэрэглэлээр нисэн гарах, стандарт хэрэглэлээр нисэн ирэх, хэрэглэлээр ойртолт үйлдэх, тусгай зориулалтаар ашиглах агаарын зайн болон нисгэгчид хэрэгцээтэй бусад мэдээллийг агуулсан цахим ой санамжийг;

GLONASS гэж Глобал навигацийн хиймэл дагуулын системийн ОХУ-ын хэсгийг;

GNSS гэж Глобал навигацийн хиймэл дагуулын системийг;

GPS гэж Глобал байршил тогтоох системийг;

GPS-мэдрэгч гэж FMS-ийн хүрээнд навигацид ашиглагдах GPS нэгж төхөөрөмжийг;

NANU гэж NAVSTAR хэрэглэгчид хандсан анхааруулах мэдэгдлийг (GPS NOTAM);

Анхдагч хэлбэрийн навигацийн систем (Primary-means navigation system) гэж заалтын нарийвчлал болон тохирлын шаардлага хангадаг, гэхдээ үйлчилгээний байнгын бэлэн байдал, тасралтгүй байх шаардлага хангахгүй байж болох, өгөгдсөн үйл ажиллагаа, эсхүл нислэгийн үе шатанд зөвшөөрөгдсөн навигацийн системийг. Нислэгийг тодорхой цаг хугацааны үечлэлд хуваан, үйл ажиллагааны зохих хязгаарлалт тогтоосноор аюулгүй байдлыг хангадаг;

RAIM (хүлээн авагчийн бие даасан тохирлын мониторинг) / (receiver autonomous integrity monitoring) гэж нислэгийн тухайн үе шатанд TSO-ын GPS-ийн байршлын тохирлыг харуулах чадварын шаардлагаас хэтэрсэн алдааг илрүүлэх нислэгийн GPS-хүлээн авагч/процессорын ажиллагааг. Энэ нь шаардлагатай үед ил харагдах, болон/эсхүл анхааруулах дуут дохио өгнө;

RAIM Анхааруулга (RAIM боломжгүй гэсэн мэдээ) / (RAIM not available message) гэж GPS хиймэл дагуулаас авсан тухайн навигацийн байршлын заалтын тохирол найдваргүй болохыг анхааруулах дохиог;

Бие даасан хэлбэрийн навигацийн систем (Sole-means navigation system) гэж заалтын нарийвчлал, тохирол, бэлэн байдал болон тасралтгүй ажиллагаа зэрэг навигацийн системийн 4 үзүүлэлтийн шаардлагыг бүгдийг нь хангах боломжийг өгөгдсөн үйл ажиллагаа, эсхүл тухайн нислэгийн үе шатанд агаарын хөлөгт олгох үүрэгтэй, зөвшөөрөгдсөн навигацийн системийг;

Нэмэлт хэлбэрийн навигацййн систем (Supplemental means navigation system) гэж аливаа бие даасан хэлбэрийн навигацййн системтэй заавал хамт ашиглах ёстой навигацййн системийг.

19.205. Нисгэгчийн мэргэшил

(а) Хөлгийн дарга, GPS хэрэглэлээр ойртолт үйлдэхэд ашигладаг FMS-ийг багтаасан, тухайн GPS-хүлээн авагчийн маяг болон загварыг ашиглах ур чадвараа амжилттай шалгуулсныг нисгэгчийн дэвтэрт нь шалгагч-нисгэгч баталгаажуулснаас бусад тохиолдолд, GPS-хүлээн авагч ашиглан, IFR-ээр хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг хэрэгжүүлэхгүй.

(б) Хэрэв нисгэгч нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц стандартын дагуу GPS-хүлээн авагч, эсхүл FMS-ийг ашиглах мэдлэг болон ур чадвараа харуулах нислэгийн шалгалтыг амжилттай өгсөн бол шалгагч-нисгэгч тухайн GPS-хүлээн авагчийн маяг болон загвар, эсхүл FMS-ийг нисгэгчийн дэвтэрт нь баталгаажуулсан тэмдэглэл хийнэ.

19.207. Анхдагч GPS үйл ажиллагаа

GPS-төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацййн системээр ашиглан, IFR-ийн дагуу агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа этгээд нь:

- (1) дараах нөхцөлийг бататгана:
 - (i) тухайн GPS-төхөөрөмжийг CAA 2129 маягтад Level 1-ээр зөвшөөрснийг;
 - (ii) төлөвлөж байгаа IFR-ийн үйл ажиллагаанд GPS-төхөөрөмжийг үндсэн хэлбэрийн навигацййн системээр ашиглахыг зөвшөөрч, тухайн агаарын хөлгийн CAA 2129 маягтад баталгаажуулсан тэмдэглэл хийснийг;
- (2) тухайн GPS-төхөөрөмжийг агаарын хөлгийн нислэгийн заавар, эсхүл агаарын хөлгийн нислэгийн зааврын нэмэлтэд заасны дагуу ашиглана;
- (3) хэрэв тухайн агаарын хөлөг нь Монгол Улсын FIR-д үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол агаарын хөлгийг дараах байдлаар тоноглосон болохыг бататгана:
 - (i) агаарын тээврийн үйл ажиллагааны хувьд, GPS-хүлээн авагчаас өөр, бие даасан хэлбэрийн, ажиллагаатай 2 навигацййн системээр. Бие даасан хэлбэрийн навигацййн систем нь тухайн нисэж байгаа нислэгийн замд тохирсон байх ёстой;
 - (ii) агаарын тээврийн үйл ажиллагаанаас бусад үйл ажиллагааны хувьд, GPS-хүлээн авагчаас өөр, бие даасан хэлбэрийн, ажиллагаатай 1 навигацййн системээр. Бие даасан хэлбэрийн навигацййн систем нь тухайн нисэж байгаа нислэгийн замд тохирсон байх ёстой;
- (4) хэрэв GPS-д суурилсан хэрэглэлээр ойртолт үйлдэх журмыг ашиглахыг зорьж байгаа бол тухайн нисэн хүрэх цэгт ирэх баримжаат цагийн RAIM урьдчилсан мэдээг нисэн гарахаас өмнө дараах байдлаар авна:
 - (i) агаарын хөлгийн GPS-хүлээн авагчийг ашиглан; эсхүл

- (ii) ИНД-172-ын дагуу олгосон НХУ-ний байгууллагын гэрчилгээ эзэмшигчээс;
- (5) нислэгийн замын болон аэродромын навигацийг дараах байдлаар гүйцэтгэдэг болохыг бататгана:
 - (i) тухайн нислэгийн замын хувьд, хүчинтэй, нисэж байгаа замтай холбоотой бүсийн нислэгийн зургийн өгөгдлийг агуулсан GPS өгөгдлийн санг ашиглаж байгааг;
 - (ii) GPS бүрийн өгөгдлийн сангийн сонгосон зам болон илтгэх цэгүүдийн хоорондын зайн нарийвчлал болон хүлээн зөвшөөрөхүйц үндэслэлийг нислэгийн замын болон бүсийн хүчинтэй нислэгийн зурагтай харьцуулан шалгах хэлбэрээр;
- (6) бүх GPS хэрэглэлийн ойртолтыг, тухайн нислэг үйлдэж байгаа ойртолтын журмын хувьд, хүчинтэй, хэвлэн нийтэлсэн Хэрэглэлээр ойртолт үйлдэх зурагт хамаарах GPS өгөгдлийн санд агуулагдсан хүчинтэй өгөгдлийг ашиглан, зөвшөөрөгдсөн хэрэглэлийн ойртолтын журмын дагуу гүйцэтгэдэг болохыг бататгана;
- (7) хэрэв нислэгийн замын үе шатанд RAIM анхааруулга 10 минутаас дээш хугацаагаар дэлгэцэд мэдээлсэн, эсхүл тухайн GPS-төхөөрөмж DR горимд 1 минутаас дээш хугацаагаар ажилласан бол:
 - (i) хяналт тавьж байгаа холбогдох НХУ-ын үйлчилгээний нэгжид мэдэгдэнэ;
 - (ii) агаарын хөлгийн байрлалыг, IFR-ээр зөвшөөрсөн өөр навигацийн систем ашиглан 10 минут тутамд бататгана;
- (8) дэлгэцэд RAIM анхааруулга гарсан үед хэрэглэлээр ойртолт үйлдэхгүй;
- (9) хэрэв ИНД-91.405-ын дагуу бэлтгэл аэродром шаардлагатай бол дараах нөхцөлийг бататгана:
 - (i) тухайн бэлтгэл аэродром нь GPS навигацаас өөр, бүрэн ажиллагаатай радио навигацийн туслах хэрэгсэлд суурилсан, хэрэглэлээр ойртолт үйлдэх түгээгдсэн журмаар үйлчилдэг болохыг;
 - (ii) агаарын хөлгийг тухайн радио навигацийн туслах хэрэгслийг ашиглах чадвартай навигацийн төхөөрөмжөөр тоногдсон болохыг.

19.209. Бие даасан хэлбэрийн GPS үйл ажиллагаа

Аливаа этгээд нь Монгол Улсын FIR-д зөвхөн GPS-мэдрэгч ашигладаг, бие даасан хэлбэрийн навигацийн систем ашиглан агаарын хөлгөөр IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

19.211. Нэмэлт хэлбэрийн GPS үйл ажиллагаа

(а) Аливаа этгээд нь 19.207(1)-ийн IFR-ийн навигацийн шаардлага хангаагүй GPS-хүлээн авагч ашиглан агаарын хөлгөөр үйл ажиллагаа гүйцэтгэхгүй.

(b) Аливаа этгээд нь IFR-ээр үйл ажиллагаа гүйцэтгэж байхдаа, 19.207(1)-ийн шаардлага хангаагүй GPS-хүлээн авагчийг зөвхөн нэмэлт мэдээлэл авах зорилгоор ашиглаж болно.

19.213. GPS-ээс авсан зайн мэдээлэл

(a) Хэрэв RAIM байхгүй, мөн өмнөх 10 минутад байгаагүй бол GPS-төхөөрөмж ашиглан IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн даргыг GPS-ээс авсан зайн мэдээлэл ашиглахыг хориглоно.

(b) Хөлгийн дарга GPS-ээс авсан зайн мэдээллийг байрлалаа илтгэхдээ ашиглах бол тухайн зай нь GPS өгөгдлийн санд агуулагдаж байгаа тогтсон баримжаат цэгт холбоотой GPS-ийн зай болохыг тодорхой заах үүрэгтэй.

(c) Хөлгийн дарга GPS-ээс авсан зайн мэдээллийг ILS/DME, эсхүл LOC/DME хэрэглэлээр ойртолт үйлдэх журамд ашиглах бол дараах нөхцөлийг бататгах үүрэгтэй:

- (1) GPS-ын зайн мэдээлэл нь тухайн хэрэглэлээр ойртолт үйлдэх хүчинтэй, хэвлэн нийтэлсэн журамтай холбоотой DME-ийн солбицолд суурилсныг;
- (2) DME-ийн солбицлын тухайн үеийн мэдээллийг GPS өгөгдлийн санд байнгын хэлбэрээр хадгалдаг болохыг.

19.215. Минимум нислэгийн түвшин

Энэ Дүрмийн дагуу түгээгдсэн минимум нислэгийн түвшинг үл харгалзан, GPS-төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр, эсхүл бие даасан хэлбэрийн навигацийн системээр ашиглан, IFR-ийн дагуу үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн хувьд, минимум нислэгийн түвшин гэж:

- (1) НХУ-ын зөвшөөрөлд багтсан, холбогдох НХУ-ын нэгжийн тогтоосон түвшинг; эсхүл
- (2) нислэгийн замын зураг, бүсийн зурагт үзүүлсэн, эсхүл хүснэгтэд үнэлэгдсэн боловч зурагдаагүй, Монгол Улсын AIP-д багтсан, хэвлэн нийтэлсэн замын хувьд, дараах хамгийн өндөр түвшинд, эсхүл түүнээс дээш байх IFR-ийн аяллын түвшингийн хүснэгтээс сонгосон хамгийн бага түвшинг:
 - (i) тухайн замын минимум аюулгүй түвшин (MSA);
 - (ii) хязгаарласан минимум огтлох түвшин;
 - (iii) тухайн замд нөлөөлдөг галт уулын аюултай зоон, аюултай бүс, цэргийн үйл ажиллагааны бүс, эсхүл хязгаарлалттай бүсийн дээд хязгаар.

19.217. Үнэлгээ хийгдээгүй замын нислэг

(a) Энэ зүйлийн (b)-г харгалзан, Монгол Улсын FIR-д IFR-ээр GPS-төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр ашиглан үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн даргад төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг зөвшөөрнө, хэрэв:

- (1) 4200м (FL140), эсхүл түүнээс дээш, тогтоогдсон уулархаг бүсэд; эсхүл

(2) 3000м (FL100), эсхүл түүнээс дээш, бусад агаарын зайд үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа бол.

(b) Хэрэв НХУ зөвшөөрсөн бол хяналттай агаарын зайд төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг агаарын хөлгийн даргад зөвшөөрнө.

(c) IFR-ээр GPS-төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр ашиглан үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгийн даргад 3000м-ээс (FL100) доош төлөвлөөгүй нислэгийн зам сонгохыг зөвшөөрнө, хэрэв:

(1) НХУ зөвшөөрсөн бол;

(2) НХУ тухайн нислэгийн саадыг давах хангалттай өндрийг локатораар тасралтгүй хянадаг бол.

19.219. Нислэгийн төлөвлөгөө

(a) Хэрэв “G” үсэг ICAO-гийн нислэгийн төлөвлөгөөний маягтын 10-р нүдэнд бичигдсэн бол хөлгийн дарга IFR-ийн дагуу агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагааг зөвхөн GPS-төхөөрөмжийг анхдагч хэлбэрийн навигацийн системээр, эсхүл бие даасан хэлбэрийн навигацийн системээр ашиглан гүйцэтгэх үүрэгтэй.

(b) Энэ Бүлгийн шаардлагыг хангаснаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг ICAO-гийн нислэгийн төлөвлөгөөний маягтын 10-р нүдэнд “G” үсэг бичихийг хориглоно.

E Бүлэг - Нөөц

F Бүлэг - Хангамжийн байгууллагын зөвшөөрөл

Энэ Бүлэг ИНД-145-д шилжсэн.

G Бүлэг - Аюулгүйн хамгаалалт

19.353. Аюулгүйн хамгаалалтын хяналтад хамаарах агаарын хөлөг, хувь хүнд тавих хязгаарлалт

ИНД-91.9-ийн дагуу Дарга эрх олгосноос бусад тохиолдолд, аливаа этгээдийг аюулгүйн хамгаалалтын хяналтаар орсон этгээдэд дараах зүйлийг дамжуулах, эсхүл түүнийг аюулгүйн хамгаалалтын хяналт хийгдсэн агаарын хөлгийн бүхээгт байгаа этгээд авах боломжтой байрлалд тавихыг хориглоно:

(1) галт зэвсэг;

(2) аюултай, эсхүл хор хөнөөл учруулах зэвсэг, эсхүл бусад төрлийн хэрэглэл;

(3) сум хэрэгсэл;

- (4) тэсрэх бодис, эсхүл хэрэгсэл, эсхүл гэмтэл учруулах бодис, эсхүл агаарын хөлгийн, эсхүл агаарын хөлгийн бүхээгт байгаа хүмүүсийн аюулгүй байдалд аюул учруулахад ашиглаж болох аливаа төрлийн хэрэгсэл.

19.355. Хориглох зүйлс

Зохих ёсоор эрх олгогдоогүй этгээдэд дараах үйлдэл хийхийг хориглоно:

- (1) аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд нэвтрэх боломжийг хянах зорилгоор хийсэн хаалга, хашаа, эсхүл аэродромын бусад хаалт, хашааг нээлттэй, эсхүл хамгаалалтгүй, эсхүл бусад хэлбэрээр хяналтгүй үлдээх; эсхүл
- (2) аюулгүйн хамгаалалттай бүс, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл үйл ажиллагааны бүсэд зөвшөөрөлгүй нэвтрэхээс сэргийлэхэд ашиглагдаж байгаа хашаа, хаалт, эсхүл бусад зүйлийн дэргэд, эсхүл дээр нь хяналтын арга хэмжээнээс зайлсхийх боломж олгох зорилгоор, аливаа эд зүйлийг урьдчилан байрлуулах, тавих, эсхүл үлдээх.

19.357. Нисэх буудлын нэвтрэх үнэмлэх

(а) Дарга нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл бусад нэвтрэх баримт бичгийг энэ дүрмийн дагуу олгож, эсхүл зөвшөөрч болно, хэрэв:

- (1) үнэмлэх, эсхүл баримт бичиг авах хүсэлт гаргасан этгээдийг тодорхойлох аюулгүйн хамгаалалтын зохих шалгалтыг хуулийн дагуу хийсэн бол; эсхүл
- (2) тухайн этгээдийг Даргын хүлээн зөвшөөрөхүйц аюулгүйн хамгаалалтын дүйцэх өөр шалгалтад тэнцсэн гэж үзсэн бол.

(b) Энэ зүйлийн (c), (g)-г харгалзан, дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг аэродром, эсхүл навигацийн байгууламжийн аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсэд үлдэхийг хориглоно:

- (1) нисэх буудлын нэвтрэх үнэмлэхийг хувцасны гадна энгэрт, ил харагдахаар зүүсэн бол; эсхүл
- (2) энэ зүйлийн (a)-ийн дагуу зөвшөөрсөн хугацаанд өөр нэвтрэх баримт бичиг, эсхүл бусад нэвтрэх баримт бичгийг биедээ авч яваа бол.

(c) Дарга, нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигчийн нэрийг ил болгохгүй байх нь зүйтэй гэж үзсэн тохиолдолд, үнэмлэх эзэмшигчийн нэр заагаагүй нэвтрэх үнэмлэх зүүхийг зөвшөөрч болно.

(d) Энэ дүрмийн дагуу аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх зөвшөөрөл олгогдсон этгээд нь зөвхөн ажил үүргээ гүйцэтгэх зорилгоор тухайн бүсэд үлдэж болно.

(e) Хэрэв эрх бүхий этгээд шаардвал, аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх этгээд нь нисэх буудлын нэвтрэх үнэмлэх, эсхүл энэ зүйлийн (a)-ийн дагуу эрх олгосон бусад нэвтрэх баримт бичгийг шалгуулах үүрэгтэй.

(f) Хэрэв нисэх буудлын нэвтрэх үнэмлэх эзэмшигч нь үнэмлэх шаардлагатай ажлын байранд ажиллахаа больсон, эсхүл бусад шалтгаанаар үнэмлэх эзэмших эрхгүй болсон бол тухайн үнэмлэхээ олгосон эрх бүхий байгууллагад нэн даруй эргүүлэн өгнө.

(g) Энэ зүйлийн (b) нь дараах этгээдэд хамаарахгүй:

- (1) тухайн этгээдийн байнга оршин суудаг улсын засгийн газрын эрх бүхий байгууллагын, эсхүл ажил олгогчийн олгосон албан ёсны нэвтрэх үнэмлэхийг хувцасны гадна талд зүүсэн, олон улсын үйлчилгээний агаарын хөлгийн багийн гишүүнд; эсхүл
- (2) албан ажлын шаардлагаар нууцлагдмал байх шаардлагатай Монгол Улсын засгийн газрын агентлагийн аливаа албан тушаалтанд; эсхүл
- (3) хэрэв аливаа этгээд нь тухайн нислэгийн хүчинтэй суугчийн тасалбартай, эсхүл багийн гишүүн, эсхүл үйл ажиллагаа эрхлэгчийн төлөөлөгч түүнийг дагалдаж яваа бол нислэгээр явах, эсхүл нислэгээс буух зорилгоор аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсээс гарах аливаа зорчигчид; эсхүл
- (4) хэрэв тухайн нисгэгч, эсхүл тухайн нисгэгчийг дагалдаж байгаа этгээд нь нисгэгчийн хүчинтэй үнэмлэх биедээ авч яваа бол тухайн агаарын хөлөгт суух, буух, эсхүл үйлчилгээ хийх зорилгоор аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх, эсхүл бүсэд байгаа, хувийн үйл ажиллагааны агаарын хөлгийн даргад.

(h) Хэрэв нэвтрэх үнэмлэх авах хүсэлт гаргасан этгээдэд Дарга аюулгүйн хамгаалалттай бүс, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх болон үлдэхийг зөвшөөрсөн түр нэвтрэх үнэмлэх олгосон ба түүнийг 19.357(a)(1), (2)-т заасны дагуу аюулгүйн хамгаалалтын шалгалтын үйл явцын дагуу олгосон нисэх буудлын нэвтрэх үнэмлэхтэй этгээд дагалдаж байгаа бол тухайн этгээдэд 19.357(a)(1), (2)-т заасан аюулгүйн хамгаалалтын шалгалт хийхийг шаардахгүй.

19.359. Шүүхийн, эсхүл захиргааны хяналтад байгаа зорчигчийг тээвэрлэх

(a) Монгол Улсын, эсхүл гадаад улсын Засгийн газрын байгууллагаас шүүхийн, эсхүл захиргааны хяналтад байгаа этгээдийг арилжааны тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа агаарын хөлгөөр тээвэрлэхийг шаардсан тохиолдолд, тухайн этгээд харгалзагчтай аялах эсэхээс үл хамааран, санал болгосон аяллын нөхцөл байдлын талаар үйл ажиллагаа эрхлэгчид мэдэгдэнэ.

(b) Хэрэв үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн аяллыг гүйцэтгэхийг зөвшөөрсөн бол:

- (1) үйл ажиллагаа эрхлэгчийн нислэгийн аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзсэн, ИНД-119, эсхүл ИНД-129-ийн дагуу баталсан аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрөөр зөвшөөрсөн нөхцөлийг тогтооно;
- (2) тухайн хөлгийн даргад мэдэгдэнэ.

(c) Холбогдох байгууллага нь эдгээр бүх нөхцөлийг дагаж мөрдөнө.

I Бүлэг - Ажилтан

19.401. Техник үйлчилгээний ажилтны үнэмлэхийг дахин шалгах

Хэрэв Дарга тухайн эзэмшигчийн ур чадварыг тогтоох арга хэмжээ авах шаардлагатай гэж үзвэл, ИНД-66-гийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэл эзэмшигчийг дахин шалгаж болно. Хэрэв шаардлагатай бол Дарга дахин шалгалтын үр дүнд тухайн үнэмлэх, гэрчилгээ, эсхүл зэрэглэлийг өөрчилж, эсхүл цуцалж болно.

19.403. Нислэгийн хөдөлгөөний удирдагчийн ажлын цагийн хязгаарлалт

Дарга, дараах нөхцөлийг харгалзан нислэгийн хөдөлгөөний удирдагчийн албан үүргээ гүйцэтгэх ажлын цагийн үргэлжлэх хугацаанд хязгаарлалт тогтоож болно:

- (1) ажлын байрны төрөл;
- (2) өдрийн аль цагт тухайн ажил үүргийг гүйцэтгэх;
- (3) тухайн байрлал, нислэгийн хөдөлгөөний нягтаршил, эсхүл тухайн нислэгийн хөдөлгөөний удирдагчид шаардлагатай оюуны төвлөрөлтийн түвшинд нөлөөлөх бусад хүчин зүйл.

19.405. Туршин нисгэгч

Дараахаас бусад тохиолдолд, аливаа этгээдийг агаарын хөлгийн маягийн анхны загварыг шалгах, эсхүл агаарын хөлгийг туршин нисэх зорилгоор туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг хориглоно:

- (1) тухайн этгээд нь ИНД-61-ийн дагуу олгосон хүчинтэй нисгэгчийн үнэмлэх, эсхүл баталгаажуулсан зөвшөөрөл эзэмшдэг ба төлөвлөж байгаа маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэх зорилгоор туршин нисгэгчийн үүрэг гүйцэтгэхийг Дарга зөвшөөрсөн бол; эсхүл
- (2) агаарын хөлөг нь хэт хөнгөн агаарын хөлөг бөгөөд тухайн этгээд нь үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор хэт хөнгөн агаарын хөлгийн байгууллагаас зөвшөөрөгдсөн байх, хэрэв ИНД-149-ийн гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэхийг тухайн туршин нисгэгчид зөвшөөрөх эрх олгодог бол; эсхүл
- (3) агаарын хөлөг нь глайдер бөгөөд тухайн этгээд нь үйл ажиллагаа гүйцэтгэх зорилгоор глайдерын байгууллагаас зөвшөөрөгдсөн байх, хэрэв ИНД-149-ийн гэрчилгээ нь түүнийг эзэмшигчид маягийн анхны загварыг шалгах, эсхүл туршин нисэхийг тухайн туршин нисгэгчид зөвшөөрөх эрх олгодог бол.

19.407. Нөөц

19.409. Глайдерын ажилтан

(а) Глайдерын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байдалд тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) глайдерын сурагч;
- (2) глайдерын мэргэшсэн нисгэгч;
- (3) хөөргөх нэмэлт төхөөрөмжийн баталгаажуулсан тэмдэглэл;
- (4) зорчигч зөөх эрх;
- (5) С-категорийн глайдерын багш;
- (6) В-категорийн глайдерын багш;
- (7) А-категорийн глайдерын багш;
- (8) хөөргөх нэмэлт төхөөрөмжийн зааварчилгааны баталгаажуулсан тэмдэглэл;
- (9) хэрэглэлийн нислэгийн зааварчилгаа өгөх эрх;
- (10) IFR-ээр нисэх эрх.

(b) Глайдерын инженерийн дараах мэргэшлийг эзэмшихэд шаардлагатай мэдлэг, чадварын шаардлага болон эдгээр мэргэшлийн эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) ангилал-2 зөвшөөрөл;
- (2) ангилал-3 зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;
- (3) ангилал-4 зөвшөөрөл, W, M, болон P дэд зэрэгтэй;
- (4) С-зэрэглэл;
- (5) S-зэрэглэл;
- (6) R-зэрэглэл;
- (7) E-зэрэглэл, E2, E3 болон E4 дэд зэрэгтэй.

19.411. Ханг-глайдер болон параглайдерын нисгэгч

Ханг-глайдер болон параглайдерын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байдалд тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) эхлэн суралцагчийн зэрэглэл;
- (2) сурагчийн зэрэглэл;
- (3) дунд түвшний зэрэглэл;
- (4) ахлах зэрэглэл;
- (5) параглайдерын зэрэглэл-1;
- (6) параглайдерын зэрэглэл-2;
- (7) параглайдерын зэрэглэл-3;
- (8) параглайдерын багшийн зэрэглэл;
- (9) параглайдерын зорчигчийн зэрэглэл;
- (10) ангилал-1 ханг-глайдерын багшийн зэрэглэл;

- (11) ангилал-2 ханг-глайдерын багшийн зэрэглэл;
- (12) тусгай ур чадварын зөвшөөрөл.

19.413. Хэт хөнгөн агаарын хөлөг нисгэгч

Микролайтын нисгэгчийн дараах ангилал эзэмших болон тэдгээр ангиллын хүчинтэй байдалд тавих шаардлага, эрх, хязгаарлалтыг ИНД-д заасан:

- (1) сурагч-нисгэгчийн үнэмлэх;
- (2) А, В, С бүлгийн сурагч-нисгэгчийн зэрэглэл;
- (3) дунд түвшний нисгэгчийн үнэмлэх;
- (4) А, В, С бүлгийн дунд түвшний нисгэгчийн зэрэглэл;
- (5) ахлах нисгэгчийн үнэмлэх;
- (6) А, В, С бүлгийн ахлах нисгэгчийн зэрэглэл;
- (7) хэт хөнгөн агаарын хөлгийн багш-нисгэгчийн гэрчилгээ (нөхцөлт);
- (8) хэт хөнгөн агаарын хөлгийн багш-нисгэгч;
- (9) А, В, С бүлгийн хэт хөнгөн агаарын хөлгийн багш-нисгэгчийн зэрэглэл;
- (10) эрх бүхий шалгагч (АТО).

--oOo--